

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ ИРҮҮҮЛСЭН, ХЯНАН ҮЗСЭН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

(2017 оны III улирлын байдлаар)

Судалгаа, шинжилгээний алба

АГУУЛГА

НЭГ. МЭДҮҮЛЭГ ИРҮҮЛСЭН БАЙДАЛ	3
ХОЁР. ХЯНАЖ, ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ	7

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Мэдүүлгийн тоо, сараар (7821)	3
Зураг 2. Мэдүүлгийг хянуулахаар ирүүлсэн шалтгаан (1822).....	3
Зураг 3. Томилогдох албан тушаалын ангилал (1822)	4
Зураг 4. Томилогдох албан тушаалын төрөл (1822)	4
Зураг 5. Хянан хариу хүргүүлсэн байдал.....	7

Хүснэгт

Хүснэгт 1. 2017 оны III дугаар улиралд 10-аас дээш тооны мэдүүлэг ирүүлсэн байгууллага, үндэслэл	5
Хүснэгт 2. Мэдүүлгийн үндэслэл, байршил.....	6
Хүснэгт 5. Хянан хариу хүргүүлсэн байдал, төрлөөр	7
Хүснэгт 6. Ашиг сонирхлын илт зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдсон мэдүүлэгийг санал болгож буй байдлаар	Error! Bookmark not defined.
Хүснэгт 7. Хянан үзсэн ажилтан, шийдвэрлэлтийн тоо	Error! Bookmark not defined.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (цаашид “мэдүүлэг” гэх)-ийг хууль заасны дагуу томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт ирүүлдэг. Тус газарт 2017 оны III дугаар улиралд 1822 ХАСУМ хүлээн авсан байна.

Үүнээс 7 болон 8 дугаар сард хүлээн авсан мэдүүлгийн тоо харьцангуй бага байна. Тайлант хугацаанд тус газарт хянуулахаар ирүүлсэн мэдүүлгийн 642 нь албан тушаал ангилал, зэрэглэл дэвшихээр, 635 нь шилжин томилогдохоор, 492 нь нийтийн албанд шинээр томилогдохоор хянуулж байгаа бол 33 нь жинхлэн томилогдохоор, ангилал зэрэглэл буурахаар болон сүүлийн 2 жил ажил эрхлээгүй тус бүр 9 мэдүүлэг хянуулсан байна.


Тайлант хугацаанд Цагдаагийн ерөнхий газар 350, Онцгой байдлын ерөнхий газар 71, Төрийн банк 62, Хил хамгаалах ерөнхий газар 50, Зэвсэгт хүчний жанжин штаб 46, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 43, Гадаад харилцааны яам 42 мэдүүлэг ирүүлсэн нь бусад байгууллагуудтай харьцуулахад өндөр байна.

Нийт 1822 мэдүүлгийн 1533 нь буюу 84.1 хувийг нийслэлээс, харин 289 буюу 15.9 хувийг аймгуудаас ирүүлсэн байна. Хөвсгөл, Дорнод, Төв, Орхон аймгууд 19-28 мэдүүлэг ирүүлсэн нь бусад аймагтай харьцуулахад өндөр байна. Улаанбаатар хотод байрладаг байгууллагуудад томилогдохоор мэдүүлгээ ирүүлсэн этгээдээс 580 нь шилжин томилогдохоор, 512 нь албан тушаалын ангилал, зэрэглэл дэвшихээр, 396 нь нийтийн албанд шинээр томилогдохоор, 29 нь жинхлэн томилогдохоор, 7 нь албан тушаалын ангилал, зэрэглэл буурахаар, 1 нь эрхлэх асуудлын чиг үүрэг өөрчлөгдөх шалтгаантай байна. Орон нутагт байршилтай байгууллагуудад томилогдохоор мэдүүлгээ ирүүлсэн этгээдээс 96 нь нийтийн албанд шинээр томилогдохоор, 55 нь шилжин томилогдохоор, 13 нь албан тушаалын ангилал, зэрэглэл дэвших шалтгаанаар ирүүлсэн нь харьцангуй их байна.

Авлигатай тэмцэх газар нь III дугаар улиралд 96 мэдүүлэгтэй холбоотой хариу өгч буцаасан байна. Үүнд: томилсон тушаал, захирамжийг хүчингүй болгуулахаар 27, томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлээгүй 24, холбогдох материал дутуу 33, хуулийн үйлчлэл хамаарахгүй гэсэн шалтгаанаар 12 мэдүүлгийг буцаажээ. Томилсон тушаал, захирамжийг хүчингүй болгуулахаар буцаасан 27 мэдүүлгийн 6 нь Төрийн банкнаас ирсэн нь бусад хариу хүргүүлсэн байгууллагаас хамгийн өндөр тоотой байна.

НЭГ. МЭДҮҮЛЭГ ИРҮҮЛСЭН БАЙДАЛ


Зураг 1. Мэдүүлгийн тоо, сараар (7821)




Зураг 2. Мэдүүлгийг хянуулахаар ирүүлсэн шалтгаан (1822)



Зураг 3. Томилогдох албан тушаалын ангилал (1822)



Зураг 4. Томилогдох албан тушаалын төрөл (1822)



Хүснэгт 1. 2017 оны III дугаар улиралд 10-аас дээш тооны мэдүүлэг ирүүлсэн байгууллага, үндэслэл


Байгууллага	ХАСУМ шалгах үндэслэл, шалтгаан								Нийт
	Нийтийн албанд шинээр томилогдох	Албан тушаалын ангилал, зэрэглэл дэвших	Албан тушаалын ангилал, зэрэглэл буурах	Шилжин томилогдох	Эрхлэх асуудлын чиг үүрэг өөрчлөгдөх	Жинхлэн томилогдох	Зөрчил арилгах	Сүүлийн 2 жил ажил эрхлээгүй	
Цагдаагийн ерөнхий газар	45	135		17					350
Онцгой байдлын ерөнхий газар	25	32		14					71
Төрийн банк	12	35		15					62
Хил хамгаалах ерөнхий газар	11	22		17					50
Зэвсэгт хүчний жанжин штаб	4	13		29					46
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	8	22		13					43
Гадаад харилцааны яам	5	1		36					42
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	2	8		8		2		2	40
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	15	18		6					39
Гаалийн ерөнхий газар		5		28					33
Баянзүрх дүүргийн ЗД	4	1		3		19		1	28
Нийслэлийн МХГ	17	3		6					26
Батлан хамгаалах яам	2	1		13					25
Тагнуулын ерөнхий газар	19	2		3					24
Татварын ерөнхий газар		7		15					22
Хууль зүй, дотоод хэргийн яам	3	1		13		4			21
Сүхбаатар дүүргийн ЗД	19			1					20
Нийслэлийн ЗД	1	12		5					18
Хөгжлийн банк	4	4		9		1			18
Монгол Улсын Ерөнхий прокурор	4	7		6					17
Зам, тээврийн хөгжлийн яам	2	6		6					14
Монгол Улсын Их Хурлын Тамгын газар	4	1		8					13
Хан-Уул дүүргийн ЗД	1			2		1			13
Төрийн тусгай хамгаалалтын газар		8		3					11
Үндэсний статистикийн хороо	5	3		3					11
Бусад	280	295	9	356	1	6	1	6	954
Нийт	492	642	9	635	1	33	1	9	1822

Хүснэгт 2. Мэдүүлгийн үндэслэл, байршил

Аймаг, нийслэл	ХАСУМ шалгах үндэслэл, шалтгаан								Нийт
	Нийтийн албанд шинээр томилогдох	Албан тушаалын ангилал, зэргэлэл дэвших	Албан тушаалын ангилал, зэргэлэл буурах	Шилжин томилогдох	Эрхлэх асуудлын чиг үүрэг өөрчлөгдөх	Жинхлэн томилогдох	Зөрчил арилгах	Сүүлийн 2 жил ажил эрхлээгүй	
Улаанбаатар	396	512	7	58	1	29		8	1533
Хөвсгөл	13	11		4					28
Дорнод	4	11	1	5					21
Орхон	5	7		7					19
Дорноговь	5	7		4			1		17
Баянхонгор	5	6	1	3					15
Өмнөговь	5	3		6				1	15
Сүхбаатар	7	6		2					15
Хэнтий	8	5		1		1			15
Завхан	4	7		3					14
Сэлэнгэ	3	11							14
Дундговь	3	4		3		3			13
Өвөрхангай	2	1		1					13
Булган	4	5		3					12
Говьсүмбэр	6	3		2					11
Ховд	3	5		3					11
Говь-Алтай	5	3		1					9
Архангай	3	4							7
Баян-Өлгий	2	4		1					7
Увс	3	4							7
Дархан-Уул	2	2		2					6
Төв	4	12		4					2
Нийт	492	642	9	635	1	33	1	9	1822

ХОЁР. ХЯНАЖ, ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Зураг 5. Хянан хариу хүргүүлсэн байдал



Хүснэгт 3. Хянан хариу хүргүүлсэн байдал, төрлөөр

№		Тоо	Хувь
ЗӨРЧИЛГҮЙ			
1.	Ашиг сонирхлын зөрчил үүсээгүй	1459	80.1
ЗӨРЧИЛТЭЙ			
1.	Ашиг сонирхлын зөрчил илт үүсэх нөхцөл байдал тогтоогдсон	6	0.3
АНХААРУУЛСАН			
1.	Ажлын байрны тодорхойлолт болон хуульд заасан шаардлага хангаагүй	88	4.8
2.	Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсныг анхааруулсан	32	1.8
3.	Ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон	16	0.9
БУЦААСАН			
1.	Томилсон тушаал, захирамжийг хүчингүй болгуулахаар буцаасан	27	1.5
2.	Томилох эрх бүхий байгууллага, а/т-с ирүүлээгүй	24	1.3
3.	Холбогдох материал дутуу	33	1.8
4.	Хуулийн үйлчлэлд хамаарахгүй	12	0.7
	Хянаж дуусаагүй	125	6.9
	Дүн	1822	100.0

--oOo--